

1. Улсын бүртгэлийн гэрчилгээтэй байх;
2. Сургалтын хөтөлбөрийн агуулгад нийцсэн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх;
3. Тухайн мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх, багц цагийн богино хугацааны сургалтын чиглэлээр батлагдсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөтэй байх;
4. Сургалтын үйл ажиллагаа эрхлэх журамтай байх
5. Сургалтын чиглэлд нийцсэн сургалтын танхим, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, лаборатори, мэргэжлийн номын сан, байнгын үйл ажиллагаатай хэвлэх, хувилах төхөөрөмж, интернэт бүхий компьютерийн танхим, суралцагчдад зориулсан амрах, хувцас солих өрөө гэх мэт сургалтын орчныг бүрдүүлсэн байх;
6. Батлагдсан орон тоо бүхий сургалтын нэгж эсхүл төгсөлтийн дараахь сургалтын асуудал хариуцсан орон тооны ажилтантай байх;
7. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадавхи бүхий багшлах бүрэлдэхүүнтэй байх, сургалт удирдах багшийн 70-аас доошгүй хувь нь тухайн байгууллагын үндсэн ажилтан байх;
8. Сургалт удирдах багшийн чадавхийг тасралтгүй сайжруулах 3-5 жилийн төлөвлөгөөтэй байх;
9. Тухайн чиглэлээр нэг жилд хэдэн суралцагч сургах хүчин чадлыг тооцсон 3-5 жилийн төлөвлөгөөтэй байх.